



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№231 /440/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.22

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ДӨРӨВ ДЭХ ЭЭЛЖИЙН БҮРЭЛДЭХҮҮН ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан Цэргийн багуудын ээлж хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн билээ.

Дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүн энэ сарын 2-ны өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад ажилласан бөгөөд тэд ажиллагааны газар оронд доорх үүргийг гүйцэтгэжээ. Үүнд Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны газар орны бодит байдалтай танилцах, НҮБ-ын "UNMISS" энхийг сахиулах ажиллагааны удирдлага болон холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцох, Цэргийн багт шаардлагатай ажиллагааны газар орны зах зээлээс худалдан авах боломжтой бараа материалыг судлах, худалдааны байгууллагуудтай танилцах, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг худалдан авах гэрээ байгуулах, Цэргийн багийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн зохион байгуулахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, -Мотобуудлагын батальонуудын ээлж хүлээлцэх ажиллагааг зохион байгуулж, дараагийн ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулсан хэмээн албаныхан онцлов.

БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгээд буй хурандаа О.Заяатаар ахлуулсан мотобуудлагын батальоны сүүлийн ээлжийн бие бүрэлдэхүүн тун удахгүй эх орондоо ирэх болно.



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны дөрөв дэх цуврааны 180 гаруй цэргийн алба хаагч өнөөдөр буюу энэ сарын 21-ний өдөр эх орондоо ирлээ.

Тэднийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны дарга хурандаа Т.Мөнхбаяр нар хүндэтгэн угтсан юм.

Энэ удаа дээрх бүрэлдэхүүнийг тус мотобуудлагын батальоны захирагчийн орлогч хурандаа Н.Гантөмөр ахалж ирсэн юм.

Мөн тэдний хамт Батлан хамгаалахын

Энэ үеэр ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг хэлсэн үгэндээ "Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүргээ нэг жил гаруйн хугацаанд нэр төртэйгөөр гүйцэтгэж, өнөөдөр эх орондоо ирж буй Та бүхэндээ ЗХЖШ-ын удирдлагын өмнөөс баяр хүргэе. Та бүхэн үүргээ амжилттай гүйцэтгэж, эх орон, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөж чадсанд талархал илэрхийлье. Та бүхэн хайртай бүхэнтэйгээ хэд хоног сайхан амарч, ажиллагааны үеийн ядрал алжаалаа тайлж, аав, ээж, ахан дүүс, хань, үр хүүхдүүдийн хамтаар шинэ оноо сайхан угтаарай" гэдгийг онцлолоо.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2022 ОНЫ "ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА"-ААР ТОДОРЛОО

Бахархалт түүх, амжилт бүтээл, арвин үйлсээ дархлан буй Байлдааны гавьяаны улаан тугийн одонт болон Байлдааны гавьяаны одонт Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамт олон Баянзүрх дүүргийн 2022 оны "Шилдэг байгууллага"-аар шалгарч Засаг даргын нэрэмжит өргөмжлөлөөр шагнагдлаа.

Тус хамт олон 2021-2022 онд нийгмийн хариуцлагын хүрээнд болон түүхт ойгоо угтан олон арван ажлуудыг дүүргийн Засаг даргын тамгын газар, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулжээ.

Тухайлбал Баянзүрх дүүргийн "Хөгжлийн төв"-тэй хамтран "Сэтгэлийн өглөг аян", Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянзүрх дүүргийн цэргийн штабтай хамтран 100 ширхэг хайлаас модыг тарих арга хэмжээ, "Энхийн цэрэг дэлхийн цэрэг" хөшөөт

төгөлд мод тарих арга хэмжээг зохион байгуулж, Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зорилго бүхий "Бидний бахархал" төслийн хүрээнд зохион байгуулсан цуврал тоглолтууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан цэрэг эх орны сэдэвт тоглолтууд, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтарсан арга хэмжээ, "Хавдар судлалын үндэсний төв"-өөс санаачлан хэрэгжүүлж буй "Хөгжим эмчилгээний хөтөлбөр"-ийн хүрээнд үндэсний болон сонгодог хөгжмийн тоглолтуудыг амжилттай зохион байгуулсны зэрэгцээ Баянзүрх дүүргийн соёлын ордны багш нар болон цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээнд оролцогч хүүхдүүдэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан зэрэг томоохон ажлуудыг төлөвлөн хийж гүйцэтгээд байгаа билээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-13	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.457	3.460
EUR	3.683	3.695
CNY	492	494
RUB	48.00	50,80
JPY	25.80	26,00
KRW	2.67	2.69

ЗУРХАЙ



2022.12.22 / ПҮРЭВ ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 29

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.39-17.02

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Хурыцахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.



**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 659,605,567

Эдгэрсэн

Нийт: 632,708,981

Нас барсан

Нийт: 6,678,106

